

# **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**АБТС ББСБ ХХК-ИЙН  
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР  
ДУУСГАВАР БОЛГОСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Бага тойруу/14200/, Сүхбаатарын талбай 8/1, СИТИ ТАУЭР, 15 давхар 1504/2 тоот.

Утас: 77551090

И-мэйл: [info@silversoroban.mn](mailto:info@silversoroban.mn) Вэб хуудас: [www.silversoroban.mn](http://www.silversoroban.mn)

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо Бага тойруу/14200/, Сүхбаатарын  
талбай гудамж 8/1, СИТИ ТАУЭР, 15  
давхар 1504/2 тоот Утас: (976) 77551090

2026 оны 03 сарын 03 өдөр  
Дугаар А/26/22

Г ХАРААТ БУС АУДИТОРЫН Т

**ХАРААТ БУС АУДИТОРЫН  
ТАЙЛАН**

**ДҮГНЭЛТ**

Бид 2025 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “АБТС ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд “АБТС ББСБ” ХХК-ийн 2025 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, материаллаг алдаагүй үнэн зөв, шударгаар, толилуулж тайлагнасан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт тусгасан болно.

Бид санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу танай компаниас хараат бусаар ажилласан бөгөөд ёс зүйн дүрэмд заасан шаардлагуудад нийцүүлсэн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт, нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай хэмжээний зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Бидний хийсэн аудитын ажилд аудитын гол асуудал бол компани нь цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулж нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг алдагдуудахгүй байх нь чухал юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайлан болон аудиторын тайлангаас бусад мэдээлэл**

Санхүүгийн тайлангаас бусад мэдээллийн үнэн зөв байдалд компанийн удирдлага хариуцлага хүлээх ба компани нь жилийн тайландаа бусад мэдээллийг ил тодоор илэрхийлэх үүрэгтэй байдаг. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой нийцэж байгаа эсэх эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм.

### **Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### **Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлан нь залилан болон алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин буй материаллаг буруу илэрхийллийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан болон алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг хэмжээнд тооцогддог.

### **Хэрэглээний хязгаарлалт**


Энэхүү тайлан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу "АБТС ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчид зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,  
АУДИТОР



Г.БАЯСМАА




## АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.12.31	2025.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	803,727,395.70	965,092,148.55
Зээл	12,345,427,441.75	21,973,431,872.66
Факторингийн тооцооны авлага		
Үүсмэл санхүүгийн хөрөнгө		
Хөрөнгө оруулалт		
Бусад санхүүгийн хөрөнгө	4,515,319,114.18	1,839,705,486.33
<b>Санхүүгийн хөрөнгийн дүн</b>	<b>17,664,473,951.63</b>	<b>24,778,229,507.54</b>
Татвар,НДШ-ийн авлага		
Үндсэн хөрөнгө	1,420,211,700.05	1,365,143,016.82
Биет бус хөрөнгө	6,242,720.48	5,908,006.49
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад санхүүгийн бус хөрөнгө	627,450,132.03	2,280,421,137.64
<b>Санхүүгийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,053,904,552.56</b>	<b>3,651,472,160.95</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,718,378,504.19</b>	<b>28,429,701,668.49</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	4,700,726,389.40	3,303,001,712.46
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр		
Бусад эх үүсвэр	8,640,610,000.00	18,431,225,431.48
Үүсмэл санхүүгийн өр төлбөр		
Бусад санхүүгийн өр төлбөр	2,664,889.95	12,774,961.26
Хоёрдогч өглөг		
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)		
<b>Санхүүгийн өр төлбөрийн дүн</b>	<b>13,344,001,279.35</b>	<b>21,747,002,105.20</b>
Татвар, НДШ-ийн өр төлбөр	299,640,142.80	457,122,914.98
Нөөц (болзошгүй өр төлбөр)		
Хойшлогдсон татварын өр төлбөр		
Бусад санхүүгийн бус өр төлбөр		
<b>Санхүүгийн бус өр төлбөрийн дүн</b>	<b>299,640,142.80</b>	<b>457,122,914.98</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>13,643,641,422.15</b>	<b>22,204,125,020.18</b>
<b>ӨМЧ</b>		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	4,689,480,000.00	4,689,480,000.00
Өмчийн бусад хөрөнгө	679,074,000.00	679,074,000.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	706,183,082.04	857,022,648.31
<b>НИЙТ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,074,737,082.04</b>	<b>6,225,576,648.31</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,718,378,504.19</b>	<b>28,429,701,668.49</b>




## АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.12.31	2025.12.31
<b>Хүүгийн орлого</b>		
Банканд байршуулсан хөрөнгийн	11,388,437.94	130,481,047.21
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн		
Зээлийн	1,842,373,258.07	3,119,918,427.28
Үнэт цаасны		
Бусад		
Хүүгийн орлогын буцаалт		
<b>Хүүгийн орлогын дүн</b>	<b>1,853,761,696.01</b>	<b>3,250,399,474.49</b>
<b>Хүүгийн зардал</b>		
Итгэлцлийн үр шимийн	653,947,823.85	466,263,919.32
Зээлийн	898,975,901.64	1,772,380,791.22
Үнэт цаасны		294,575,342.46
Бусад		
Хүүгийн зардлын буцаалт		
<b>Хүүгийн зардлын дүн</b>	<b>1,552,923,725.49</b>	<b>2,533,220,053.00</b>
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>300,837,970.52</b>	<b>717,179,421.49</b>
Эрсдэлийн сангийн зардал		4,395,921.97
<b>Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого</b>	<b>300,837,970.52</b>	<b>712,783,499.52</b>
<b>Бусад орлого</b>	<b>999,357,266.53</b>	<b>293,996,629.13</b>
Хүүгийн бус орлого	997,376,398.91	293,134,524.68
Бусад орлого, олз	1,980,867.62	862,104.45
<b>Бусад зардал</b>	<b>1,152,372,024.21</b>	<b>883,361,297.33</b>
Хүүгийн бус зардал	1,138,432,854.39	847,311,901.63
Бусад зардал, гарз	13,939,169.82	36,049,395.70
<b>Татварын төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>147,823,212.84</b>	<b>123,418,831.32</b>
Орлогын татварын зардал		15,946,822.70
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>147,823,212.84</b>	<b>107,472,008.62</b>
Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал		
<b>Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал</b>	<b>147,823,212.84</b>	<b>107,472,008.62</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		
<b>Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>147,823,212.84</b>	<b>107,472,008.62</b>




## АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Өмчийн бусад хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,689,480,000.00</b>	<b>679,074,000.00</b>	<b>558,359,869.20</b>	<b>5,926,913,869.20</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>4,689,480,000.00</b>	<b>679,074,000.00</b>	<b>558,359,869.20</b>	<b>5,926,913,869.20</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			147,823,212.84	147,823,212.84
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчит гарсан өөрчлөлт				
Хуваарилсан ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,689,480,000.00</b>	<b>679,074,000.00</b>	<b>706,183,082.04</b>	<b>6,074,737,082.04</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			43,367,557.65	43,367,557.65
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>4,689,480,000.00</b>	<b>679,074,000.00</b>	<b>749,550,639.69</b>	<b>6,118,104,639.69</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			107,472,008.62	107,472,008.62
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчит гарсан өөрчлөлт				
Хуваарилсан ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,689,480,000.00</b>	<b>679,074,000.00</b>	<b>857,022,648.31</b>	<b>6,225,576,648.31</b>



## АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024.12.31	2025.12.31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Эзэлийн хүүгийн төлбөрт хүлээн авсан	1,842,373,258.08	8,549,640,371.11
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	4,700,726,389.40	597,200,000.00
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан		
Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан		
Бусад	1,013,296,436.35	
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>7,556,396,083.83</b>	<b>9,146,840,371.11</b>
Олгосон эзэл	9,750,720,635.33	14,123,241,034.57
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	653,947,823.85	3,107,486,185.27
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн		
Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн		
Ажиллагсад олгосон	204,937,120.68	277,167,916.01
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	22,896,049.09	30,685,989.50
Ашиглалтын зардалд төлсөн	5,358,729.82	
Бусад		331,660,651.02
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>10,637,860,358.77</b>	<b>17,870,241,776.37</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,081,464,274.94)</b>	<b>(8,723,401,405.26)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан		
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан		
Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан		
Хүлээн авсан ногдол ашиг		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		4,400,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн		
Бусад		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>-</b>	<b>4,400,000.00</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>(4,400,000.00)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрийн эзэлээс хүлээн авсан	2,143,000,000.00	8,032,500,000.00
Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		1,600,000,000.00
Бусад		
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>2,143,000,000.00</b>	<b>9,632,500,000.00</b>
Банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрийн эзэлд төлсөн	520,800,000.00	593,363,358.29
Хоёрдогч өглөгт төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Бусад		
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>520,800,000.00</b>	<b>593,363,358.29</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,622,200,000.00</b>	<b>9,039,136,641.71</b>
Валютын ханшийн зөрүү	1,221,216,720.66	(149,970,483.60)
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(238,047,554.28)</b>	<b>161,364,752.85</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,041,774,949.98</b>	<b>803,727,395.70</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>803,727,395.70</b>	<b>965,092,148.55</b>

